



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/33

Мандалговь

Түгээмэл тархацтай ашигт малтмалын
хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.7 дахь заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 70 дугаар тогтоол, Ашигт малтмал газрын тосны газрын 8/356 тоот дүгнэлт, Өндөршил сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал зэргийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймгийн Өндөршил сумын нутагт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг хавсралтад заасан аж ахуйн нэгжид тогтоосон хэмжээ, солбицлын дагуу 3 жилийн хугацаагаар олгосугай.

2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг аж ахуйн нэгжид хуулийн дагуу олгон, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Өндөршил сумын Засаг дарга (У.Алтанхүү) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 25, 26, 27 дугаар зүйлүүдэд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг болон байгаль орчныг хамгаалах үүргээ хэрэгжүүлж ажиллахыг "Талын мэтл" ХХК (Ж.Ууганбаяр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822110082

Аймгийн Засаг даргын 2023 оны 01 сарын 20
өдрийн 4/33 дугаар захирамжийн хавсралт

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН
ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТАЛБАЙ

Д/д	Өргөдлийн дугаар	Сумын нэр	Аж ахуйн нэгжийн нэр	Талбай н нэр	Уртраг	Өргөрөг	Талбайн хэмжээ га
1.	ХА-48000195 - 001-NE	Өндөршил	"Талын мэтл"ХХК	Хөх	108° 16' 35.99"	45° 25' 8.18"	387.59
					108° 15' 1.61"	45° 25' 32.26"	
					108° 15' 1.62"	45° 24' 30"	
					108° 17' 31"	45° 24' 30"	
					108° 17' 31"	45° 24' 55.21"	
					108° 17' 11.08"	45° 25' 0.91"	
					108° 17' 11.08"	45° 24' 51.99"	
					108° 16' 17.59"	45° 24' 51.99"	